



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/91

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн В сураггүй алга болсонтой холбогдуулан Булган сум дахь Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнтэй эрэн хайх ажиллагааны зардалд 5,524,050 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 5,524,050 (таван сая таван зуун хорин дөрвөн мянга тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Тус олгож буй санхүүжилтийг зориулалтын дагуу зохих журамд нийцүүлэн зарцуулж, тайлагнахыг холбогдох сумдын Засаг дарга нар, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Э.Уртнасан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 04-ний өдрийн
А/91 дүгээр захирамжийн хавсралт



ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6	7
1.	Цэвэрлээгээний спирт	л	5	5000	250.000	Усны гүнд шумбах багаж хэрэгслийн цэвэрлэгээ
2.	Эм	ш	1	56200	56200	Усны гүнд шумбаж байгаа алба хаагчдад
3.	АИ-92	л	5	2950	14750	Цахилгаан үүсгүүрт
4.	Масло	л	2	17000	34000	Цахилгаан үүсгүүрт
5.	ДТ	л	100	3550	355000	01-38 ХОЕ (ОБХ)
6.	АИ-92	л	60	2950	177000	66-70ХОЕ (ОБХ)
7.	АИ-92	л	20	2950	59000	Цахилгаан үүсгүүрт
8.	АИ-92	л	4	2950	11800	Цахилгаан үүсгүүрт
9.	АИ-92	л	120	2950	354000	32-95 ХОУ (Цагдаа)
10.	АИ-92	л	54	2950	159300	29-57 ОРО (Цагдаа)
11.	Аарц, боз, чацаргана	ш	300	--	570000	Эрэн хайх ажиллагаанд ажиллаж буй Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтсийн алба хаагчдын өдрийн хоол, цай
12.	Хоол	ш	300	---	3708000	
13.	Дүн	---	---	---	5,524,050	----

-oOo-